



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 1172

Улаанбаатар хот

**Дээврийн засварын ажилд хөрөнгө
гаргах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.6 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Соёлын ордон, 2 дугаар хорооны 16, 8 дугаар байрны дээврийн хар цаас гамшигт үзэгдлийн нөлөөгөөр хууларч гэмтсэн тул дээрх барилга, байгууламжуудын дээврийн засварын ажлыг чанар, үр дүнтэй зохион байгуулсугай.

2.Засварын ажилд шаардагдах төсвийг хавсралтаар баталж, 5,351,500 (Таван сая гурван зуун тавин нэгэн мянга таван зуун) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3.Ажлын явц, үр дүнгийн талаар тухай бүр танилцуулж, санхүүгийн тайланг 10 хоногийн дотор ирүүлэхийг Соёлын ордон (Б.Алтанцоож), Их хангай сууц өмчлөгчдийн холбоо (З.Нармандах)-нд, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




А.СҮХБОЛД

AJIL\2026 он ажил\захирамж

1226010234

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 04 дугаар сарын 01-ны өдрийн
8772 дугаар захирамжийн хавсралт



СОЁЛЫН ОРДНЫ ДЭЭВРИЙН ЗАСВАРТ ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Бүгд үнэ
1	Бетон тэгшлэгч	ш	20	25,000	500,000
2	Праймер /1 сав-18 литр/	лааз	10	115,500	1,155,000
3	Тэгшлэгч шүрл	ш	2	11,500	23,000
4	Чулуугүй хар цаас BLG Техноникель	Бо	16	150,000	2,400,000
Нийт үнэ:					4,078,000

2 ДУГААР ХОРООНЫ ИХ ХАНГАЙ СӨХ-НЫ ДЭЭВРИЙН ЗАСВАРТ
ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Бүгд үнэ
1	Цемент	ш	6	25,000	150,000
2	Праймер /1 сав-18 литр/	лааз	2	115,500	231,000
3	Чулуутай хар цаас Техноникель	Бо	3	160,000	480,000
4	Чулуугүй хар цаас BLG Техноникель	Бо	1	150,000	150,000
5	Мастика	ш	1	187,500	187,500
6	Прүс мод	Бо	3	25000	75,000
Нийт үнэ:					1,273,500